



ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



JAPAN INTERNATIONAL
COOPERATION AGENCY

**Улаанбаатар хот дахь ХБИ-
ийн нийгмийн оролцоог
дэмжих төсөл (DPUB)
Мэдээллийн эмхэтгэл №19**

Боловсролын салбарынхан хөгжлийн бэрхшээлийн нөлөөллийн сургалтанд хамрагдлаа. (2018.09.13)



Багийн чиглүүлэгч багш “хөгжлийн бэрхшээл”-ийн талаар оролцогчидтой ярилцаж байна.


**JICA DPUB фэйсбүүк хуудсанд LIKE
дарж нэгдээрэй!!**

Төслийн фэйсбүүк хуудсанд LIKE дарсан нийт хүний тоо **3209** болж, маш олон хүнд төслийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл хүрэх боллоо. Цаашид ч гэсэн олон сонирхолтой мэдээллүүдийг та бүхэнд хүргэхийн тулд хичээн ажиллах болно.



9-р сарын 6, 10-ны өдрүүдэд Боловсролын салбарынхан Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET)-д хамрагдлаа. Сургалтанд Нийслэлийн Боловсролын газрын арга зүйчид, Налайх дүүргийн 109-р сургуулийн багш нар нийт 35 хүн оролцсон. Сургалтын үеэр Налайх дүүрэгт тог тасарсан боловч багш нар сургалт дуустал идэвхтэй оролцлоо. Улаанбаатар хотод Япон улсын буцалтгүй тусламжаар сургууль барих, засварлах ажлууд явагдаж байна. Шинээр баригдах сургуулиудад налуу зам, хөтөч зам суурилуулах, тэмдэг тэмдэглэгээг ойлгомжтой байдлаар хийх гэх мэтээр бүх хүүхдэд ээлтэй орчинг бүрдүүлэх юм. Хэдий сургуулийн барилга хүртээмжтэй болсон ч багш нарын ойлголт хандлага өөрчлөгдөхгүй бол хүүхдүүдийн сурах орчин хангалттай бүрдэхгүй учраас DET сургалтаар дамжуулж хөгжлийн бэрхшээлийн талаар зөв ойлголт өгөхийг зорьсон юм. Багш нар DET-ийн сургагч багш нартай “Хөгжлийн бэрхшээл гэж юу вэ?” гэсэн асуултын талаар харилцан ярилцаж, цаашид ямар үйл ажиллагаа явуулах талаар хэлэлцлээ. Дараагийн удаа Баянзүрх, Хан-Уул дүүргийн сургуулиудад DET сургалт хийхээр төлөвлөж байна.

**DPUB төсөлд МУИС-ын оюутан дадлага
хийж байна. (2018.09.27)**



Цэцэнгоо

Сайн байцгаана уу. 9-р сарын 25-ны өдрөөс ЖАЙКА-ийн Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих техникийн хамтын ажиллагааны төсөлд 3 долоо хоногийн хугацаатай дадлага хийхээр болсон МУИС-ХУС-Япон орон судлалын 4-р курсын оюутан Энхжаргалын Цэцэнгоо байна. Би өнгөрсөн жил Японы Цүкүба их сургуульд 1 жил суралцсан бөгөөд энэ хугацаанд Сургуулийн өмнөх боловсролын талаар судалгааны ажил бичсэн. Тус судалгаандаа Монгол улсын сургуулийн өмнөх боловсрол, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын талаар голлон бичсэн ба хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан цэцэрлэгийн тоо хүрэлцэхгүй, цэцэрлэгт явахыг хүссэн ч хамрагдаж чадахгүй байгаа хүүхдүүд олон болохыг ойлгосон. Мөн хүүхдээ цэцэрлэгт өгч чадахгүй байгаагаасаа болоод хөдөлмөр эрхлэх боломжгүй эцэг эхчүүд ч олон байна. 3 долоо хоног хэдийгээр богино хугацаа ч төслийн үйл ажиллагаагаар дамжуулан олон зүйлийг сурч, хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэгээ нэмэгдүүлнэ гэдэгтээ итгэлтэй байна. Дадлага хийх хугацаандаа төслийн хамт олноос заавар, зөвлөгөө авч хичээн ажиллах болно. Баярлалаа.

DPUB Холбоо барих хаяг

Хаяг:

Монгол улс, Улаанбаатар-15160,
Нэгдсэн үндэстний гудамж-5, Засгийн
газрын 2-р байр, ХНХЯ

Фэйсбүүк хуудас:

[https:// www.facebook.com/jicadpub](https://www.facebook.com/jicadpub)

Цахим хуудас:

[https:// www.jica.go.jp/project/ mon-golia/015/index.html](https://www.jica.go.jp/project/mon-golia/015/index.html)

И-мэйл:

dpub.jica@gmail.com

НҮБ дэх ажил болон Ази Номхон далайн бүс нутаг дахь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 10 жил

НҮБ ESCAP нь гишүүн орнуудынхаа Хөгжлийн бэрхшээлийн талаарх холбогдох мэдээллүүдийг цуглуулан, цацах үүрэгтэй. 2001 оны байдлаар цахим хуудасны хэрэглээ аль хэдийн дэлгэрсэн байв. Гэвч хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй цахим хуудсууд байхгүй байлаа. Жишээ нь, дэлгэц унших программ ашигласан ч зарим мэдээллийг унших боломжгүй, зураг болон графикуудад үсгэн тайлбар байхгүй, мөн өнгөний контраст нь муу тул харахад хүндрэлтэй зэрэг одоогийнхоор бол мэдээллийн хүртээмжтэй байдал хангагдаагүй байв. Ингээд миний анхны хариуцсан ажил ESCAP-ын цахим хуудсыг хүртээмжтэй болгох байлаа. Тухайн үед цахим хуудсыг бүхэлд нь хүртээмжтэй болгох



Ахлах зөвлөх Чиба Хисао

хүндрэлтэй байсан тул эхний ээлжинд Нийгмийн хөгжлийн хэлтсийн цахим хуудсыг хүртээмжтэй болгосон. Мэдээллийн хүртээмжийг сайжруулах нь “НҮБ, Ази Номхон далайн бүс нутаг дахь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 10 жил (1993-2002)”-н үйл ажиллагааны төлөвлөгөөний нэг зорилт байсан юм. Энэ 10 жилд Ази Номхон далайн бүс нутаг дахь улс орнуудын ХБИ-ийн нийгмийн оролцоог дэмжихийн тулд НҮБ ESCAP-аас гаргасан тунхаглалын дагуу улс орнуудын Засгийн газар үйл ажиллагааны зорилтыг хангахаар ажиллаж байсан. Гэвч тунхаглал гаргасан ESCAP-ын өөрийнх нь цахим хуудас хүртээмжгүй байвал улс орнуудын Засгийн газарт зааварчилгаа өгөх боломжгүй. Энэ утгаараа хөгжлийн бэрхшээлийн салбарт туршлага багатай ч мэдээллийн технологийн талаасаа хувь нэмрээ оруулж чадсандаа би их баяртай байдаг. Үүнээс хэдийгээр НҮБ, Хөгжлийн бэрхшээлийн салбарын мэргэжилтэн биш ч гэсэн өөрийн мэдлэг, туршлага тус болохыг мэдэж авсан юм. Харин үүнээс цаашаа надад Хөгжлийн бэрхшээлийн салбарын мэргэжлийн түвшний мэдлэг шаардлагатай болсон... (Үргэлжлэл бий...)

DAISY номын хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллаж байна. (2018.08.16)

Та бүхэн Daisy (Дэйзи) гэж сонсож байсан уу? Энэ үг нь Digital Accessible Information System гэсэн үгийн товчлол бөгөөд хүртээмжтэй мэдээллийн систем юм. Тухайлбал хэвлэмэл материал уншихад хүндрэлтэй хүмүүс ч гэсэн ашиглах боломжтой



Хигашида мэргэжилтэн Заяатай хамт Монгол-Японы төвийн номын сантай танилцлаа.

хүмүүст ч гэсэн Дэйзи номын талаар мэдээлэл хүргэхийн тулд уулзалт зохион байгуулахаар төлөвлөж байна.

Ур чадварыг дээшлүүлэх Давтлага сургалт ~DET сургагч багш нарын сургалт~ (2018.09.14)

9-р сарын 7-ны өдөр Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET)-ын сургагч багш нар Монгол-Япон төвд зохион байгуулагдсан ур чадвар дээшлүүлэх давтлага сургалтанд хамрагдлаа. Энэ удаагийн сургалтын үндсэн сэдэв нь “Нүүр хагарах”, “Хүртээмжтэй орчныг сайжруулахад шаардлагатай Барилгын стандарт” гэсэн сэдвүүд байсан ба сургагч багш Гэрэлцэцэг, Лхамжав нар хичээл заалаа. Тэд хөгжлийн бэрхшээлийн салбарт олон жил ажилласан туршлагатай бөгөөд тус сургалтын үеэр өөрсдийн мэдлэг чадварыг бусадтайгаа хуваалцлаа. “Нүүр хагарах” аргачлалын тухайд нэг нэгнээ мэддэг хүмүүс эсвэл анх удаа уулзаж буй тохиолдолд гэх мэтээр нөхцөл байдалд тохируулан уур амьсгал бүрдүүлэх талаар ярилцлаа. Барилгын стандартын лекцийн үеэр хаалганы өргөн, налуу замын хэм, хөтөч замын хэмжээ гэх мэт тодорхой нарийн стандартуудыг суралцлаа. Мөн “Стандарт байдаг ч хэрэгждэггүй...” гэсэн асуудлын талаар ярилцаж, юуны өмнө хүмүүсийн ойлголтыг өөрчлөх нь чухал болохыг хэлэлцлээ. Сургалтын үеэр DET-ээр



Давтлага сургалтын үеэр

“Сонсоод унших аудио ном” зэрэг байдаг. DPUB төслийн зүгээс Монгол-Японы төвд цөөн тооны Дэйзи ном бэлэглэсэн бөгөөд өнгөрсөн 7 хоногт Заяатай хамт тус төвийн номын санд очиж, хэрхэн ашиглах нөхцөл байдалтай танилцлаа. Цаашид бусад

дамжуулж нөлөөллийн ажил хийх нь ямар чухал ач холбогдолтой болохыг улам илүү ойлгосон гэдэгт итгэлтэй байна. Сургагч багш нар цаашид ч гэсэн барилгын салбар болон бусад холбогдох салбаруудад DET сургалтыг зохион байгуулах болно.